



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/230

Есөнбулаг сум

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэн батлах тухай" 212 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны "Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм батлах тухай" 211 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд баригдсан Цогт сумын Баянтоорой тосгоны халаалтын зуух, дулаан цэвэр усны шугам сүлжээний угсралтын ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Ж.Мянганбаяр	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Гишүүдэд:	П.Хулан	(Аймгийн Төрийн архивын хэлтсийн дарга)
	З.Жаргалтуяа	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дэд бүтцийн хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн)
	Д.Отгонжаргал	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Салбарын хяналт зохицуулалтын хэлтсийн эрчим хүчний хяналтын улсын байцаагч)
	Д.Лхагвасүрэн	(Цогт сумын Засаг дарга)
	Б.Баяртогтох	(Цогт сумын Засаг даргын Тамгын газрын санхүү албаны дарга)
	Б.Баярбаатар	(Цогт сумын Баянтоорой тосгоны захирагч)
	С.Содбаяр	(Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахлах дэслэгч)
	Б.Батбилэг	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын техникийн хяналтын улсын байцаагч)
	М.Энх-Орчлон	(Орон нутгийн өмчийн газрын Хууль, хяналт шинжилгээ үнэлгээ,

D:zahiramjZax ZD 2026

8200980377

- Х.Биндэръяа (дотоод хяналт шалгалтын мэргэжилтэн)
("Алтай-Улиастайн цахилгаан түгээх систем" ТӨХК-ийн ерөнхий инженерийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч) (хангагч)
- Л.Баасанхүү ("Кингсий инженер энд констракшн" ХХК-ийн захирал) (зохиогч)
- Б.Мөнхзаяа ("Хурд хүч чадал" ХХК-ийн менежер) (гүйцэтгэгч)

Нарийн бичгийн дарга: М.Мөнхцэцэг (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Инженерийн дэд бүтцийн хариуцсан мэргэжилтэн)

2.Барилга, шугам сүлжээний угсралтын ажлыг ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, зураг төсөл, холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг 2026 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн дотор танилцуулахыг комисс (Ж.Мянганбаяр)-т үүрэг болгосугай.

3.Холбогдох акт, баримт бичгийг үндэслэн орон нутгийн өмчид бүртгэхийг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг), барилга байгууламжийн урсгал зардлыг төсөвт тусгаж, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг "Хурд хүч чадал" ХХК (Г.Батсуурь)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

